

## ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

Төлөвлөлт бол сургалтын амжилтын гол юм. Сайн хөтөлбөр боловсруулах нь багш бүрийн тулгамдсан асуудал байдаг.

Ямар хөтөлбөрийг сайн хөтөлбөр гэх вэ?

- Үйл ажиллагааны зорилтоо тодорхойлсон
- Сурагчдад юуг, хэзээ, яаж сурахыг мэдээлсэн Сурагчдын үүрэг хариуцлагыг тодорхойлсон Сурагчдын ташаа ойлголттой болохгүй байхаас сэргийлсэн
- Агуулгаа элментарчилсан
- Үнэлгээ нь зорилго, зорилттойгоо нийцсэн
- Үнэлгээний шалгуураа гаргаж хүүхдэд тодорхой болсон

Багш хичээлээ төлөвлөхдөө дараах асуултад хариулах шаардлагатай

Хөтөлбөрийн бүтэц	Асуулт	Гол санаа
Хэрэгцээ, зорилго	Яагаад?	Яах гэж үүнийг судлаж байгаа вэ? Ямар хэрэгтэй вэ?
Агуулга	Юу?	Юуг судлах вэ?, юуг мэддэг чадцаг болох вэ? яасар чадварыг хөгжүүлэх вэ?
Арга зүй	Яаж?	Яаж, ямар арга замаар, ямар дидактик шийдэл хийж энэ мэдлэг чадварыг эзэмших/эүэмшүүлэх вэ?
Хэрэглэгдэхүүн	Юугаар?	Юу ашиглаж яаж хийх вэ?
Үр дүн	Юунд?	Юунд хүрэх вэ?, юуг үнэлэх вэ? Хүүхдийн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилд гарч буй өөрчлөлтийг үнэлэх үү? Мэдлэгийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлэх үү? Хичээлээ үнэлэх үү? Эдгээр үнэлгээг юунд яаж ашиглах вэ? зэрэг олон асуудлууд урган гарна. ,

Хичээлийн төлөвлөлт нь зорилгоо тодорхойлохоос эхлэнэ. Хичээлийн зорилгыг зөвхөн агуулгад үндэслэн тодорхойлсноор сурагчдын өмнөх мэдлэг төсөөлөл, хэрэгцээ сонирхлыг харгалзан, багшийн үзүүлэх, сурагчийн хийх үйл ажиллагааны бодит боломжийг тооцож хичээлийг удирдан чиглүүлэх аргаа төлөвлөхөд бэрхшээл тулгардаг.

Зорилгыг тодорхойлохдоо сурагчдын өмнөх мэдлэг, төсөөлөл, сонирхол хэрэгцээнд үндэслэн мэдлэг бүтээх үйл ажиллагааг дэмжих, хандлага төлөвшилд хувь нэмэр оруулах талаас нь тооцно.

Сургалтыг мэдлэг бүтээх, чадвар эзэмшүүлэх бүхэл бүтэн дидактик үйл ажиллагаа хэмээн үзэж сургалтын зорилгыг тэрхүү үйл ажиллагааны дидактик нэгж байдалтай томъёолно. Өөрөөр хэлбэл бүлэг сэдвээ нэгж хичээлүүдэд, нэгж хичээлээ ээлжит хичээлүүдэд, ээлжит хичээлээ дидактик алхмуудад хувааж болно. Тэгвэл зорилго нь

- Бүлэг сэдвийн зорилт нь нэгж хичээлүүдийн зорилтоос
- Нэгж хичээлийн зорилт нь ээлжит хичээлийн зорилтуудаас
- Ээлжит хичээлийн зорилт нь дидактик алхмуудын зорилтоос тогтох байдлаар шатлан эрэмбэлүүлж тодорхойлж болно.

Зорилгодоо уялдуулан агуулгын хүрээгээ сонгоно. Дидактик анализ хийн агуулгаа сонгохдоо даоаах зүйлсийг анхаараарай.

- Агуулгын хамгийн гол амин сүнс нь юу вэ? Ямар суурь ойлголт суурь зарчим, гол хууль ямар шалгуур, арга барил чадварыг тухайн агуулгаар төлөөлүүлэн дэвшүүлж байгаа вэ?
- Сонгосон агуулгын чухам юу нь хүүхдэд чухал, амьдралд нь хэрэгцээтэй вэ?
- Хэрэгцээ ба агуулгын амин сүнсдээ тулгуурласан агуулгын бүтэц нь ямар байх вэ?
- Агуулгаа хэрхэн бүтэцчилвэл сурагчдад энгийн, ойлгомжтой, сонирхолтой, гол зүйлдээ анхааралыг нь хандуулсан, мэтгэлцээн үүсгэсэн, мэдлэг бүтээх үйлийн орчныг бүрдүүлж чадах вэ?

Үүний тулд сурагчдын сонирхол хэрэгцээ, өмнөх мэдлэг төсөөллийг тооцож, сурагчдад ойлгомжтой, энгийн хялбар болгохын тулд шатчилсан элментарчилал хийх хэрэгтэй.

Сэдэл яаж үүсгэх вэ? Ямар асуулт тавих вэ?, Сурагчдаас ямар хариу үйлдэл, асуулт гарч болох вэ?, Түүнийг нь хэрхэн удирдаж хөтлөх вэ? зэргээр хичээлийн үйл явцыг төлөвлөж бүтэцчилэх шаардлагатай.

Ингэж хичээлийн агуулгыг элментарчилах ба бүтэцчилэх зарчмыг дидактикаар дахин бүтээх гэж нэрлэдэг. Тухайлбал:

- Бүлэг сэдвийн агуулга нь цогц чадамж, сурах арга барилд хувь нэмэр оруулахуйц бүхэллэг байна.
- Нэгж хичээлийн агуулга нь тодорхой багц мэдлэг, чадвар, аргын тухай үйлийн баримжаа олж авах, эзэмших, хөгжүүлэхэд чиглэгдсэн байна
- Ээлжит хичээлийн агуулга нь нэгж хичээлийн тодорхой нэг дидактик нэгжийг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдлаар сонгох нь зүйтэй

#### Нэгж хичээлийн төлөвлөлтөд тавигдах шаардлага

Бүтэц	Шалгуур
Нэгж хичээл	Нэгж хичээлийн агуулга/ суралцахуйн зорилт
	Агуулгын болон хичээл хоорондын залгамж холбоог гаргасан байх
	Тухайн нэгжтэй холбоотой суралцагчдын өмнөх төсөөлөл, алдаатай болон ташаа ойлголтыг илрүүлсэн үнэлгээнд хийсэн анализ
Зорилго	Сургалтын цөм хөтөлбөр, сургуулийн хөтөлбөртэй уялдуулан нэгжийн зорилгоо тодорхойлсон үнэлгээний шалгууртайгаа нийцсэн байх
Аргазүй	Ээлжит хичээлүүдийн уялдаа холбоо нь харагдахуйц, тодорхой чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн байх
	Шинжлэх ухаанч арга барилыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн арга, техникийг сонгосон байх
Агуулга	Суралцахуйн зорилтын үндсэн санааг зөв ойлгон агуулга нь тухайн ангийн түвшинд тохирсон, ТХБ үзэл санааг тусгасан байх
Үнэлгээ	Нэгж хичээлийн үнэлгээний төлөвлөлтийг хийсэн байх
	Нэгжийн үнэлгээнд хэрэглэх даалгавар, шалгуур, үнэлэх аргачлал нь тодорхой байх
Хэрэглэгдэхүүн	Тухайн нэгжид шаардагдах хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон байх
	Тухайн нэгжид хамаарах нэг ээлжит хичээлийн төлөвлөлт, ажлын хуудасыг хийсэн байх

## ЭЭЛЖИТХИЧЭЭЛ ТӨЛӨВЛӨХ

Баг жилийн төлөвлөгөө, улирлын төлөвлөгөө болон бүлэг сэдэв, нэгж хичээлийн төлөвлөлт, зорилттой уялдуулан ээлжит хичээлийн төлөвлөлтөө боловсруулдаг. Хичээлийг төлөвлөхөд маш олон зүйлийг анхаарна. Тухайлбал:

<b>Сурагчид</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ангийн сурагчдын мэдлэг, чадварын түвшин ямар байна?</li> <li>• Ямар нэгэн тусгай дэмжлэг, тусламж шаардлагатай сурагч байна уу?</li> <li>• Энэ сэдвийн талаар сурагчдын өмнөх мэдлэг, өмнөх төсөөлөл нь ямар байна вэ?</li> <li>• Сурагчдыг бүлгээр хуваарилахад бүлгийн хүүхдүүдийн харилцаа ямар байна, сургалтын явцад тусалж байна уу эсвэл саад болж байна уу?</li> </ul>
<b>Сэдэв</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Энэ сэдвийг ойлгоход ямар үндсэн мэдлэг шаардлагатай вэ?</li> <li>• Ямар чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг болох хичээл вэ?</li> <li>• Хичээлээс тодорхой ямар үр дүн гарах ёстой вэ?</li> <li>• Энэ сэдвийн холбоотой ямар ташаа ойлголтууд байдаг вэ?</li> <li>• Энэ хичээл жил ба улирлын төлөвлөгөөний аль хэсэгт хамаарах вэ?</li> </ul>
<b>Бүтэц</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн эхэнд, дунд болон төгсгөлд ямар үйлийг төлөвлөх вэ?</li> <li>• Сурагчид бие дааж ажиллахад, хосоороо болон бүлгээр ажиллахад ямар боломжууд өгөгдсөн байна?</li> <li>• Хариулт авах шаардлагатай ямар түлхүүр асуултууд/холбох, гол, / байна?</li> <li>• Ямар хэрэглэгдэхүүн шаардлагатай вэ?</li> <li>• Хичээлийн ялгарах гол онцлог юу вэ?</li> </ul>
<b>Үнэлгээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өмнөх мэдлэг чадварыг хэрхэн илрүүлэх вэ?</li> <li>• Явцын үнэлгээний ямар арга, техник, ашиглах вэ?</li> <li>• Хичээлийн аль хэсэгт суралцагчдад илүү дэмжлэг хэрэгтэй вэ?</li> <li>• Эцсийн үнэлгээнд бэлтгэх ямар боломжууд байх вэ?</li> </ul>
<b>Багш</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн чанарыг сайжруулахад ямар мэдлэг чадвар хэрэгтэй вэ?</li> <li>• Хичээлийг заахад болон төлөвлөсөн бүх ажлыг хийхэд (өөрийнхөө мэдлэг чадварт) хэр итгэлтэй байна вэ? Багш ангийн сурагчидтай ямар харилцаатай вэ?</li> <li>• Өмнөх хичээлүүд дээр болж байсан уг сэдэвтэй болон тухайн ангийн сурагчидтай холбоотой ямар онцлог зүйлүүдийг багш хичээлдээ оруулсан байна?</li> </ul>

### Хичээлийн явцад төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах

- Багш хичээлийг цааш үргэлжүүлэхээс өмнө сурагчид зааж байгаа зүйлсийн гол утгыг ойлгож мэдсэн байх шаардлагатай. Үүний тулд энэхүү гол ойлголтуудыг шалгах түлхүүр асуултуудыг багш бэлтгэх нь маш чухал.
- Явцын үнэлгээ хийхэд төлөвлөсөн асуултуудад сурагчид хэрхэн хариулж байгаа нь хичээл дээр хийгдэх дараа дараагийн даалгаварт ихээхэн нөлөөтэй.
- Сурагчдын явцын үнэлгээний даалгавар асуултууд хариулж буй байдал дээр үндэслэн шаардлагатай бол багш хичээлийн төлөвлөгөөг өөрчилнө. Иймд шаардлагатай үед хичээлийн төлөвлөгөөг өөрчлөхөд бэлэн байхаар уян хатан байх.

**Хичээлийн хөтөлбөрийг шинжлэх**

-----	Төлөвлөсөн байдал	Хөтөлбөрийн шинжилгээний дүгнэлт, саижруулах санал
Суралцахуйн зорилт		
Суралцахуйн үр дүн /зорилго/		
Ялгаатай байдал		
Өмнөх мэдлэг, төсөөлөл		

алхам		Алхам 1	Алхам 2	Алхам 3	Алхам 4
чиглэл					
Алхам тус бүрийн үндсэн санаа (Зорилт)					
Хичээлийн төлөвлөлт ба ажлын хуудас					
Зорилгын хэрэгжилтийг илрүүлэх, дасгал , даалгавар, асуулт					
Сурагчийн гүйцэтгэх үйлийн түвшин	Шинжлэх ухаанч арга барил				
	Даалгаврын гүйцэтгэлээс илрүүлэх чадвар				
	Даалгаврын гүйцэтгэл, ялгаатай байдал				
Асуултын шинжилгээ	Гол асуулт (сурагчийн боломжит хариулт)				
	Чиглүүлэх асуулт (сурагчийн боломжит хариулт)				
	Холбож буй асуулт (сурагчийн боломжит хариулт)				

Алхам тус бүрд гаргаж болзошгүй сурагчийн алдаа, санаа /Хэрэглэгдэхүүний боловсруулалт, дидактик шийдэлтэй холбоотой алдаа, асуултын боловсруулалт, асууж буй хэлбэртэй холбоотой алдаа/				
Дээрх алдааг сурагчид гаргасан нөхцөлд ямар шийдэл хэрэглэх нь хөтөлбөрт туссан байдал				
Хичээлийн төлөвлөлт ба явцын үнэлгээгээр илрүүлэх чадвар /үнэлгээний рубрук				
Хэрэглэгдэхүүний төлөвлөлт, шийдэл				
Зорилго, үр дүн, дүгнэлтийн хамаарал				

Өмнөх шинжилгээний үр дүнг ашиглан ээлжит хичээлийн хөтөлбөрийг өгөгдсөн шалгуурын дагуу шинжилж, дүгнэлт бичнэ үү.

шалгуур	Төлөвлөсөн байдал	Хөтөлбөрийн шинжилгээний дүгнэлт, сайжруулах санал
<i>Хичээлийн зорилго нь суралцахуйн зорилтод хүрхүйц, 8МАКТ эсэх</i>		
<i>Багшийн дэвшүүлсэн асуудал нь хүүхдэд тухайн сэдвийг судлах сонирхох хэрэгцээг үүсгэж, амьдралтай холбогдож байгаа эсэх</i>		
<i>Багшийн төлөвлөсөн асуулт нь хүүхэд асуудлыг олж харж, эрэл хайлт хийх үйлд чиглүүлж байгаа эсэх. Асуулт нь оновчтой эсэх.</i>		
<i>Шинжлэх ухаанч арга барилын үе шатуудыг ашиглан, бие даан мэдлэг бүтээх үйлийн алхмуудыг төлөвлөсөн эсэх</i>		
<i>Хичээлийн шинэ мэдлэг бүтээх алхмын үйл нь хичээлийн зорилго, зорилттой холбогдож, тодорхой үр дүн, дүгнэлтэд хүрэхүйц төлөвлөгдсөн эсэх</i>		
<i>Ажлын хуудсаар мэдлэг бүтээх үйлийг хөтлөн чиглүүлэх, явцын үнэлгээг хийх боломжтой байгаа эсэх</i>		